

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: ОРА-2024/34/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2024 он	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: Б.Азжаргал Утас: 70357955 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.02.22 № 22

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ
ДАРГА Ц.ОДГЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2023 оны үйл ажиллагааны зарцуулах баталсан төсөв, төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж, төсвийг 3.3 хувиар хэмнэж, төсвийн гүйцэтгэл 96.7 хувьтай тайлагнасан байна.

Анхан шатны баримтын бүрдэл хангах, түүнд хяналт хэрэгжүүлсэн байдал нь үр нөлөөгүй байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэлээр илэрч байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 01/1902 дугаартай албан бичгээр аймгийн Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй 5 автомашины шатахуун, урсгал засвар, цалин, томилолтын зардал болох 210,462.1 мянган төгрөгийн төсвийг шилжүүлсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11/04 дүгээр тогтоолоор орон нутагт ажилласны нэмэгдлийг 278,817.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосонтой холбоотой төсөв 69.4 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай байгуулж, хэрэгжилтийг хангалттай сайн буюу 90.0 хувьтай гэж үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	50,144,708.00	45,479,470.13
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,487,756,019.48	1,452,258,326.47
	Нийт хөрөнгийн дүн	1,537,900,727.48	1,497,737,796.60
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,521,860,727.48	1,481,697,796.60
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,521,860,727.48	1,481,697,796.60
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	703,975,544.00	1,213,495,693.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	686,164,392.56	1,239,880,400.87
	Үйл ажиллагааны үр дүн	17,811,151.44	(26,384,707.87)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	13,778,223.01
	Үйл ажиллагааны нийт үр дүн	17,811,151.44	(40,162,930.88)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	239,746,502.64	239,746,502.64
	Тайлант оны үр дүн	-	(40,162,930.88)
	Эцсийн үлдэгдэл	1,537,900,727.48	1,497,737,796.60
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	660,171,154.00	1,213,507,087.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	660,171,154.00	1,212,257,087.00
	Үйл ажиллагааны ЦМГ	-	1,250,000.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	1,250,000.00
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	660,171,154.00	1,212,257,087.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	660,171,154.00	1,212,257,087.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(1,250,000.00)
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,193,521,300.00	1,193,521,300.00
	Урсгал зардал	1,193,521,300.00	1,192,271,300.00
	Хөрөнгийн зардал	-	1,250,000.00
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,193,521,300.00
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс	-	1,193,521,300.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 36,353.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 8,030.2 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 28,322.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Байхгүй

3.2 Албан шаардлага:

Илрүүлэлт-1:

Албан хэрэгцээнд ажил үүрэг гүйцэтгэж буй тээврийн хэрэгслүүдэд 8,030.3 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Өглөг авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд ажилчидтай холбоотой 254.1 мянган төгрөгийн авлага, байгууллагатай холбоотой 2,238.7 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдан авлага, өр төлбөргүй ажиллах.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тээвэр шатахуун худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний алба	1	1			1			
НИЙТ		1	1			1			